



УС АМЬДРАЛ ТЭТГЭЖ, ИТГЭЛ НӨХӨРЛӨЛИЙГ БАТАТГАНА




Ус бол нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол орц юм. Нийслэл Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй усны эрэлт хэрэгцээг хангах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах зорилго бүхий Мянган сорилтын хоёр дахь Компакт гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхэллээ. Компакт гэрээний хүрээнд АНУ-ын Мянган сорилтын корпорацын 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.8 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар ус хангамжийн шинэ эх үүсвэрүүд, Монголд анх удаа ус гүн цэвэршүүлэх болон хаягдал ус дахин боловсруулах хоёр томоохон үйлдвэр байгуулахаас гадна ус хангамж, ариутгах

татуургын үйлчилгээний байгууллагуудын институцийн чадавхыг бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг сайжруулах замаар усны салбарын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ. Үр дүнд нь Улаанбаатар хотын ус хангамж 80 гаруй хувиар нэмэгдэж, нийслэл хот баруун тийш өргөжин тэлэх, тэр чинээгээр эдийн засаг өсөх таатай боломж бүрдэнэ. Энэ тухай видеог дараах холбоосоор хүлээн авч үзэх боломжтой: <https://mca-mongolia.gov.mn/news/press-news/eif-video-last>.

Эх сурвалж: Монголын Мянган сорилтын сан

ДЭЛХИЙН ӨДРИЙГ “ЭХ ДЭЛХИЙГЭЭ СЭРГЭЭ” УРИАН ДОР ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭВ



НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр 2009 оноос хойш жил бүрийн 4 дүгээр сарын 22-ны өдрийг Эх дэлхийн өдөр болгон тэмдэглэх болсон. Энэ жил энэ өдрийг дэлхий даяараа “Эх дэлхийгээ сэргээ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлээ. Эх дэлхийн өдрийг тохиолдуулан АНУ-ын Мянган сорилтын корпорацаас ирэх таван жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаа 50 хувиар нэмэгдүүлэх амлалт өгсөн юм. Мөн энэ өдөр МСК болон Элчин сайдын яамнаас усны үнэ, ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, усанд хандах хандлагыг өөрчлөх зорилго

бүхий богино хэмжээний цуврал контентынхоо [ээлжит видео](#), мөн [АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл Клеческийн илгээлт](#), [МСК-ын Монгол дахь Суурин захирал Алекс Рассины ярилцлага](#) зэрэг бусад сонирхолтой контентыг хүргэлээ. Эдгээр контентыг АНУ-ын Элчин сайдын яамны [цахим хуудас](#) болон олон нийтийн сүлжээн дэх хуудсууд ([Facebook](#), [Twitter](#), [Youtube](#))-аас үзэж сонирхох боломжтой. Түүнчлэн Монголын Мянган сорилтын сан(Монголын МСС)-аас мөн Эх дэлхийн өдрийг тохиолдуулан эх дэлхийгээс хайрлан хамгаалж, авран сэргээхийг уриалсан видеог контентыг бэлтгэж хүргэв. Видеог Монголын МСС-ийн [цахим хуудас](#), олон нийтийн сүлжээн дэх хуудсууд ([Facebook](#), [Twitter](#), [Youtube](#))-аас үзэж болно. АНУ-ын МСК нь Монгол Улсын Засгийн газартай хамтран Улаанбаатар хотын цэвэр усны хангамж, хүртээмжийг сайжруулах 350 сая ам.долларын Компакт гэрээнд гарыг үсэг зурсан бөгөөд Монголын МСС нь энэхүү Компакт гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа юм.

Эх сурвалж: Монголын Мянган сорилтын сан, АНУ-ын ЭСЯ

“НӨХӨН СЭРГЭЭЛТ 2024” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ СЭЛЭНГЭ АЙМГААС ЭХЭЛЖЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж улсын хэмжээнд уул уурхайн улмаас эвдрэлд орсон 8000 га талбайг нөхөн сэргээх зорилт тусгасан. Энэ хүрээнд БОАЖ-ын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймагт ажилласан байна. Салбар дундын хамтарсан байнгын ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг, Ялбаг гэх газарт уул уурхай болон бичил уурхай, хууль бус олборлолтын улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайнуудад шалгалт хийж, газар дээр нь ажилласан бөгөөд бичил уурхайн дүгнэлт гаргуулаагүй, журмын дагуу олборлолт, нөхөн сэргээлт хийгээгүй, хууль бусаар ашигт малтмал олборлох зорилгоор уурхайн кэмп байгуулсан, техник хэрэгслийг байрлуулан засвар үйлчилгээ хийж байсан зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Мөн тус газарт уул уурхайн болон бичил уурхай, хууль бус олборлолтын улмаас эвдрэлд орсон 200 га талбайд 4321 м3 овоолго үүссэн болохыг агаарын ортофото зураглал хийж тогтоожээ. Цаашид “Нөхөн сэргээлт 2024” арга хэмжээний хүрээнд нөхөн сэргээлт хийх орон нутгуудад төлөвлөгөөний дагуу газар дээр нь ажиллаж, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх аж.

Эх сурвалж: БОАЖЯ

УСНЫ СЭДЭВТ ЦАХИМ ХУРЛУУД

Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургууль хамтран “Улаанбаатар Ус-Цэвэр Орчин 2021” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдөр цахимаар зохион байгуулах гэж байна. Хэлэлцүүлэх илтгэлүүдийг хүлээн авч дууссан бөгөөд erkhee9191@gmail.com хаягаар холбогдох мэдээллийг авах боломжтой. **Эх сурвалж: ШУТИС-ийн Барилга, архитектурын сургууль**

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ хариуцсан байгууллагуудад зориулсан “Хөрөнгийн удирдлагын шилдэг туршлагауд: Шугаман системүүдэд эрсдэлийг удирдах дижитал шийдлүүд” (Asset Management Best Practices: Digital Solutions for Managing Risks in Linear Systems) сэдэвт вэбинар 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр болно. Энэхүү вэбинар нь үнэ төлбөргүй бөгөөд [энэ холбоосоор](#) бүртгүүлж, дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой юм байна. **Эх сурвалж: WaterOnline**